

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2022 – 07 САР | дугаар 44

ГАРЧИГ

- 1–4 Бодлогын нийтлэл
- 5–8 Зохицуулалтын мэдээ
- 9–10 Байр суурь
- 11 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний төрлүүд
- 12 Финтек дэх хэрэглэгчийн эрсдэл
- 13–17 Судлаачийн индэр
- 18–20 Санхүүгийн боловсрол
- 21–22 Компанийн засаглал
- 23–24 Олон улсын зах зээлийн мэдээ
- 25 Олон улсын хөрөнгийн зах индекс

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦ БАРИХ ӨРТӨГ, ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТ

Үргэлжлэл 10-р нүүрт

Нийтийн орон сууцнаас амины орон сууцанд жилийн дөрвөн улирал амьдрах сонирхол олон нийтийн дунд эрэлттэй байгаатай холбоотой эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихад гарах өртөг, түүнийг санхүүжүүлэх боломжийн талаар энэ удаагийн дугаараар бэлтгэлээ.

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг шаардлагын дагуу зөв төлөвлөснөөр эрчим хүчийг 40 хувиар хэмнэдэг. Уг орон сууцанд амьдрахад гарах зардлын хэмнэлтийг тооцоход дараах хүчин зүйлсийг хамаарууллаа.

Ангилал	Хэмжих нэгж	Орон сууц	Энгийн амины орон сууц	Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц
Цахилгаан (сард)	Квт/цаг	25,000–36,250	25,000–36,250	15,000–21,750
Дулаан (сард)			699,300	
Хэрэгцээний халуун ус (сард)	Төг/хүн	104,736	0	0
Нийт зардал		140,986	735,550	21,750

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-аас нэг гэр бүлийн сарын дундаж цахилгаан зарцуулалт 250 квт.ц буюу 25,000–36,250 төгрөг гардаг гэж тооцсон. Уг зардлын 40 хувь хэмнэгдэх нөхцөлд сард цахилгааны зардалд 15,000–21,750 төгрөг төлнө. Ингэснээр 10,000–14,500 төгрөг хэмнэгдэх ба жилд 120,000–174,000 төгрөг барилгын ашиглалтын 40 жилийн хугацаанд 4,800,000–6,960,000 төгрөг хэмнэгдэх юм.

2. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-аас орон сууцанд амьдарч буй хүний тоогоор усны халаалтыг тооцдог ба Монгол Улсын ам бүл гишүүдийн тоо дунджаар 4 байдаг.

3. Энгийн амины орон сууцны хувьд дулааны зардлыг шуудай шахмал түлшний өртгөөр тооцлоо. Шуудай шахмал түлш Ковид-19-өөс өмнө 3,700 төгрөгөөр зарагддаг байсан ба нэг жил 11 дүгээр сараас 4 дүгээр сар хүртэл нэг долоо хоногт нэг шуудай түлш, харин 10 болон 5 дугаар сард долоо хоногт хагас шуудай түлш хэрэглэхээр тооцлоо.

Үргэлжлэл 2-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

БҮЛГИЙН ЗЭЭЛ

Барьцаа хөрөнгийн боломж хязгаарлагдмал бүлэг хүмүүс эргэн төлөлтийн хамтын хариуцлага хүлээхээр авсан зээл.



GROUP LOAN

A loan taken by a group of individuals with limited collateral to take joint responsibility for repayment.

*Эх сурвалж:
Банк санхүүгийн тайлбар толь бичиг*



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

~~Эмнэх нь 1 р нийт~~

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ

Иргэний хуулийн 451–453 дугаар зүйлд банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий харилцааг, Улсын Их Хурлаас 2021 онд шинэчлэн баталсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хуулиар банк, эрх бүхий хуулийн этгээд болон зээлдэгч иргэн, хуулийн этгээдийн хооронд зээлийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулж өгсөн бөгөөд хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэгт “... эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталснаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг оролцоог дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлагад нийцүүлэн гүнзгийрүүлэх, зээлдэгчдийн итгэл, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүллээ.

Дижитал технологийн эрин үетэй хөл нийлүүлэн банк бус санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ дэвшилтэт

технологи ашиглан иргэд, олон нийтэд хүрэх болсноор цахим гэрээ хэлцэл байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, харилцагчийн мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлын шаардлагыг хангуулах, зээлийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх аливаа эрсдэлийг бууруулах, хяналт хариуцлагыг сайжруулахад эрх зүйн орчны шинэчлэл хийгдэж байна.

Тухайлбал финтек бүтээгдэхүүн санал болгож буй банк бус санхүүгийн байгууллагууд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, MNS ISO/IEC 27001:2021 стандартыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээг мэргэжлийн аудитын байгууллагаар баталгаажуулсан байхыг шаардаж, холбогдох нөхцөл шаардлагыг хангаж буй байдалд Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Цахим зөвлөл дүгнэлт гаргаснаар албан ёсоор бүртгэгдэхээр зохицуулсан.

Үүний зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон өр, орлогын харьцааг хангах, зээлийн мэдээллийн санд мэдээллээ бодит цагийн горимоор нийлүүлдэг байх зэрэг зээлийн үйл ажиллагаанд тавигдах холбогдох бусад шаардлагыг хангаж ажиллах юм.

ЦАХИМ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ББСБ-ын салбарт 2017 оноос технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ буюу финтекийг нэвтрүүлээд байна. Санхүүгийн

зохицуулах хорооны зүгээс энэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлж буй ББСБ-уудын хөгжлийг бодлогоор дэмжин ажиллаж байгаа бөгөөд 2017 онд энэхүү үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн 1 ББСБ байсан бол 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 32 ББСБ дэвшилтэд технологид тулгуурлан аппликэйшн ашиглан зээл олгож байна. Энэхүү бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд техник технологийг ашиглаж барьцаа хөрөнгө шаардахгүй, богино хугацаатай, бага хэмжээний зээлийг тусгай зөвшөөрөлтэй, төрийн зохицуулалттай, мэргэжлийн ББСБ-аас хялбар, түргэн, шуурхайгаар цаг, зардал хэмнэн хүү, нөхцөл багатайгаар авч байгаа нь цаашид мөнгө хүүлэлтийг хумих чухал ач холбогдолтой.

Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ санал болгож байгаа ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин нь салбарын дунджаас өндөр хувьтай байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаа ихээхэн хэмжээний гарааны хөрөнгө оруулалт шаарддагтай холбоотой бөгөөд хөрөнгө оруулалтын өртгөө дунджаар 3-аас доошгүй жилийн хугацаанд нөхөх боломжтой байдаг байна.

Технологид суурилсан үйлчилгээ үзүүлэгч банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр салбарын өрсөлдөх чадвар сайжирч, зээлийн хүү буурах боломжтой юм.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1,089,752 зээлдэгчийн 354.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 75.0 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 15.5 хувийг бүрдүүлж байна. Энэ нь ББСБ-ын салбарын зээлийн хүртээмжид эерэг нөлөөлөл үүсгэж байна. Нэг зээлдэгчид дунджаар 304.9 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 17.5 дахин бага байна.

ИРГЭД БОЛОН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ЗЭЭЛ

Иргэд: Зээл нь иргэд, аж ахуй эрхлэгч тэр дундаа бага, дунд

орлоготой иргэдийн хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зээлийн зориулалт, зарцуулалтын хувьд харилцан адилгүй байдаг. Тухайлбал зарим иргэдийн хувьд авсан зээлээ зугаа цэнгэл, баяр ёслолд зарцуулдаг бол зарим нь өрхийн санхүүгээ сайжруулах, үр ашигтай хэрэглээндээ жишээлбэл эвдэрсэн тоног төхөөрөмжийг засварлах эсвэл шинээр солих, сургалтын төлбөрөө санхүүжүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах зэрэг урьдчилан тооцоолоогүй онцгой нөхцөл байдалтай холбоотой зардлаа санхүүжүүлдэг байна.

Иргэд банканд хандаж зээл хүсэхээс илүүтэй бичил санхүүгийн байгууллагууд тэр дундаа банк бус санхүүгийн байгууллагууд үйлчлүүлэх хандлагатай байгаа нь зээл олгоход тавигдах шаардлага нь бага, барьцаа хөрөнгийн үнэлгээ өндөр, зээл судлах хугацаа богино, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэгтэй холбоотой бөгөөд тэр хэрээр хөрөнгө оруулагчид эрсдэлээ удирдах шаардлагатай байдаг.

Нөгөө талаас банк бус санхүүгийн байгууллагууд бүтээгдэхүүнээ тодорхой зорилтот сувгуудаар дамжуулах болсон бөгөөд бизнесийн түншлэлийн хүрээнд автомашин худалдаа, электрон бараа, бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ажиллаж тэдгээрийн санхүүгийн эх үүсвэрийн дутагдлыг нөхөж, мөнгөн урсгалыг сайжруулснаар бусад бизнесийн салбар үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэн улмаар тус салбарын нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь гүнзгийрсээр байна.

Аж ахуйн нэгж: Банк бус санхүүгийн байгууллагууд арилжааны банкны шаардлагад төдийлөн нийцдэггүй, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх бага хэмжээний хэрэгцээт зээлээ авч чаддаггүй бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгч иргэдэд ББСБ-ууд илүү хүрч үйлчилдэг бөгөөд ББСБ-ууд ч эрсдэл ихтэй энэхүү зах зээлийн хэрэглэгчдийн онцлогт нь тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэж ажилладаг.



НОГООН ЗЭЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 3 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ногоон санхүүжилт – Бүс нутгийн чуулган”-аар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, “Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх талаар хэлэлцэн, зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 1.3-т “Ногоон зээлийг банкны салбарт 10 хувь, ББСБ-уудад 5 хувьд хүргэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ногоон зээлд эрсдэлийн сан байгуулах, хөнгөлөлт урамшуулал олгох, ногоон зээлийн эх үүсвэрийн свопын зардлыг бууруулах зэрэг хөшүүрэг бий болгох” үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээсэн. Үүний дагуу 2022 оны 1 дүгээр улирлаас эхлэн “Монгол Улсын Ногоон таксономи”-ийн үндсэн 8 ангиллын дагуу ББСБ-уудаас “Ногоон зээлийн тайлан”-г авч эхлээд байна.

Ногоон таксономи гэдэг нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглана. Ногоон таксономи нь аль нэг салбараар хязгаарлагдахгүй, бизнесийн бүхий л салбарыг хамаарах шалгуур үзүүлэлт юм.

2021 оны жилийн эцсийн байдлаар 21 ББСБ 4,896 зээлдэгчийн 38.8 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацаанд 17 ББСБ 830 зээлдэгчид 9.9 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.7 хувийн хүүтэйгээр олгож, 18 ББСБ-ын 3,940 зээлдэгчээс 7.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 23 ББСБ 5,085 зээлдэгчийн 41.6 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1.8 хувьтай тэнцэж байна.


Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	-	-
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	249.0	2
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	-	-	6.5	8	646.1	11
4. НОГООН БАРИЛГА	1,063.9	119	950.9	138	5,003.8	777
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	6.5	6	0.5	4	153.3	7
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	10.0	3	1.8	12	217.7	29
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	296.5	9	181.0	11	619.5	14
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	8,490.4	693	5,875.3	3,767	34,753.9	4,245
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	18.5	1	18.7	3	57.9	6
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	5,767.1	374	3,100.5	1,969	23,896.2	2,424
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	2,704.8	318	2,756.1	1,795	10,799.8	1,815
НИЙТ	9,867.3	830	7,016.0	3,940	41,643.3	5,085

Ногоон зээлийн үлдэгдлийн 83.5 хувь буюу 34.8 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл, бүрдүүлж байна. Сэргээгдэх эрчим хүчний салбарт зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 92.1 хувь нь хэвийн, 2.7 хувь нь анхаарал хандуулах, 5.2 хувь нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилгын салбарын зээлийн үлдэгдэл хамгийн их буюу 7.6 хувь нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн: Монгол Улсад сүүлийн жилүүдэд үүсээд буй уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын эсрэг хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх, ойн хомсдол, доройтлыг бууруулах, нөхөн сэргээлтийг дэмжих, усны нөөцийн хомсдолоос сэргийлэхэд онцгой анхаарч, 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж ургуулах, хамгаалах Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”

үндэсний хөдөлгөөнд банк, санхүүгийн байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд мод тарьж, ургуулах амлалт өгч, “Тогтвортой санхүүжилт – Бүс нутгийн чуулган”-аар батламж хүлээн авсан билээ. Банк бус санхүүгийн салбараас 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27 банк бус нийт 7,240 модыг шинээр тарьж, өмнө нь тарьсан модоо сэргээн засварлах ажлыг хийсэн байна.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ДЭЛХИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ЗОЧИЛОО



Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийн захирал Хассан Заман, ахлах эдийн засагч Диаз Санчес болон бусад нэр бүхий төлөөлөгчид Санхүүгийн зохицуулах хорооны даргатай уулзлаа.

Уулзалтын үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Дэлхийн банк өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсын итгэлт түнш байсанд талархлаа илэрхийлээд, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад үзүүлсэн арга зүйн туслалцаа, тухайлбал тус банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл” нь санхүүгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, Хорооны зохицуулалтын шинэ салбарын эрсдэлийг тооцоход ихээхэн үр дүнтэй байгааг онцоллоо.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос банкны салбарын реформын хүрээнд системийн нөлөө бүхий банкууд олон нийтийн нээлттэй компани болохтой холбоотой зохицуулалт болон виртуал хөрөнгийн зохицуулалт, санхүүгийн салбарт учирч байгаа эрсдэлийн талаар танилцуулга хийж, энэ талаар харилцан санал солилцлоо.

Цаашид Хорооны зохицуулалтын хүрээ улам өргөжиж, санхүүгийн салбарт технологи эрчимтэй нэвтэрч буй энэ үед зохицуулалтын орчныг улам боловсронгуй болгох, Хорооны мэдээллийн технологийг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр техникийн туслалцааны төсөл үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хамтран ажиллах хүсэлтээ Хорооны дарга Д.Баярсайхан илэрхийллээ.

ГАВЬЯАТ ХУУЛЬЧДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

анхүүгийн зохицуулах хорооны дарга асан З.Нарантуяа Тулгар төрийн 2230, 2231 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111 жил, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулж Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн зарлигаар гавьяат хуульч цол хүртсэн юм. Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагууд өнөөдөр төрийн дээд цол гардсан шинэхэн гавьяатдаа хүндэтгэл үзүүллээ.



Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан "Санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд оруулсан хөдөлмөр зүтгэлд тань талархал илэрхийлэхийн хамт цаашид ч салбарынхаа хөгжил дэвшил, эдийн засагт гүйцэтгэх үүргийг улам нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг



дэвшилтэт технологид суурилан өргөжүүлэх, эрсдэлгүй, найдвартай хяналт зохицуулалттай, шударга өрсөлдөөнт зах

зээл болгон хөгжүүлэхийн төлөө хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна” гэдгийг онцлоод эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөлөө.

Гавьяат хуульч З.Нарантуяа мөн энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын дэмжлэгтэйгээр мөн салбарын оролцогчдын хамтын хүчин чармайлтаар санхүүгийн салбар сүүлийн үед эрчимтэй хөгжиж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ХАГАС ЖИЛИЙН АЖЛАА ДҮГНЭЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо 2022 оны хагас жилийн ажлаа дүгнэж тайлангийн хурлаа хийлээ. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр санхүүгийн зах зээлийг хөгжүүлж, тогтвортой байдлыг хадгалахын төлөө Санхүүгийн зохицуулах хорооны нийт хамт олон сэтгэл, зүтгэл гаргаж хичээж ажилласан. Зохицуулалтын салбаруудад ч өндөр амжилт үзүүлж чадлаа гэдгийг онцолсон юм.



Мөн тэрээр ирэх хагас жилд илүү их сорилт, илүү их ажил биднийг хүлээж байна. Санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг шинэчлэх, технологийн шинэчлэлийг дэмжих хүрээнд холбогдох хуулиудын төслийг боловсруулж УИХ-аар батлуулах, зохицуулалт хяналтын орчныг уян хатан боловсронгуй болгох, виртуал хөрөнгийн үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэх,

мөнгө угаалттай тэмцэх, 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх гээд олон ажлыг хийж хэрэгжүүлнэ гэдгийг хэллээ.

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалт хяналтын чиг үүргийнхээ хүрээнд хагас жилийн байдлаар 3614 зохицуулалттай этгээд, 2426 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллалаа. Бодлого зохицуулалтын хүрээнд хийсэн онцлох зарим ажлаас дурдвал хөрөнгийн зах зээлийн салбарт хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, баримт бичгийг бүртгэх, тавигдах нахцөл шаардлагатай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулж хялбаршуулсан ба хамтын сангийн шинэ төрөл болон биржээр арилжаалагддаг сантай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгосон. Мөн үнэт цаасны бүртгэлийн болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий зохицуулалтыг шинэчлээд байна. Бичил санхүү буюу банк бус санхүүгийн салбарт ногоон зээлийн орчинг бүрдүүллээ. Тодруулбал, банк бус санхүүгийн байгууллагууд нийт зээлийн 5 хувийг ногоон зээлд олгохын зэрэгцээ ногоон зээл болон жендерийн мэдээллийн санг үүсгэсэн. Мөн Банк бус санхүүгийн байгууллагуудын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлээд байна. Түүнчлэн банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү, түүнтэй холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамжийн зохицуулалттай болгосон.



Даатгалын салбарт ч мөн зохицуулалт, хяналт илүү уян хатан болсны зэрэгцээ даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлагыг сайжруулаад байна. Ногоон даатгалын зохицуулалтыг бий болгож мөн даатгалын эрсдэлийг тархаан байршуулах хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор банкинд байршуулсан даатгалын хөрөнгө, нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн 10 хувийг хөрөнгийн биржийн А самбарын хувьцаанд байршуулах зохицуулалттай болсон.

БАЙР СУУРЬ

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ, САЛБАРЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Энэ сарын дугаараар Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Н.Энхтуяатай ярилцлаа.



Танд энэ өдрийн мэнд хүргэе. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаар товч мэдээлэл өгнө үү.

Санхүүгийн зохицуулах хороо хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 284 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, хяналт тавин, цаашдын бодлого, стратегийг боловсруулан ажиллаж байна.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээл нь эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшнээс шууд хамааралтай салбаруудын нэг бөгөөд тус зах зээл нь манай орны дотоодын нийт бүтээгдэхүүний 6 орчим хувийг эзэлдэг. Салбарын статистик мэдээнээс үзвэл сүүлийн жилүүдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын чиглэлээр ажиллах боловсон хүчний тоо нэмэгдэж байгаа учир энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулж, мэргэшүүлэх, далд эдийн засгийг ил болгох зэргээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал тулгарсаар байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос шаардлагатай арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Салбарыг илүү тогтвортой, зөв системээр хөгжүүлэхийн тулд цаашид Санхүүгийн зохицуулах хорооноос ямар бодлого, стратегийг баримтлан ажиллах төлөвлөгөөтэй байна вэ?

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын зохицуулалтын 2022–2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Удирдлагын академийн “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх баг”-аас ирүүлсэн стратеги төлөвлөгөөний дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хүрээнд технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, түүний хяналт, зохицуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүсэлтийг цахимжуулах, цахим системд суурь мэдээллийг нэгтгэж, мэдээллийн нэгдсэн том санг үүсгэх, системийн тасралтгүй, хүртээмжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, мэргэжлийн холбоог чадавхжуулах гэх мэт зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж салбарыг олон улсын жишигт нийцүүлэн өргөн хүрээнд хөгжүүлэхээр ажиллаж байна.

Дээр дурдсан ажлуудаас нэн тэргүүнд хэрэгжүүлэх ямар ажил байна вэ?

Юуны өмнө бид салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 5 журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос батлан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж байгаа боловч олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхийн тулд бие даасан эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Иймд бид өнгөрсөн онд Дэлхийн банкны санхүүжилтээр үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулж, хамтран ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаанд хамааран төрийн бодлого, зохицуулалтад ороод удаагүй байгаа тул боловсруулагдаж буй хуулийн төсөл нь

салбарын анхдагч эрх зүйн зохицуулалт болох юм. Иймд хууль, эрх зүйн орчныг боловсруулах хүрээнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, олон улсын судалгааг хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсээр байна.

Хуулийн төсөл болон стратеги төлөвлөгөөнд тусгагдсан онцлох зохицуулалтуудаас дурдвал?

Хуулийн төсөлд тусгасан онцлох нэгэн зохицуулалт бол үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох юм. Энэхүү ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамтай 2021 оноос эхлэн хамтран ажиллаж байна.

Тус санд үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл, байршил, хэмжээ гэх мэт хэрэгцээт мэдээллүүдийг нэгтгэснээр олон нийтийг үл хөдлөх хөрөнгийн салбарын үнэн бодит мэдээллээр хангах, үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгийн гарал үүслийг тодорхой болгох, далд эдийн засгийг ил болгох, шударга өрсөлдөөнийг бий болгох, үйл ажиллагаа эрхлэгчдэд бизнесийн таатай орчин бүрдүүлэх, төрийн байгууллагуудын хийж буй ажил давхцахгүй, хоорондоо харилцан уялдаатай байх, цаг хугацаа болон хөрөнгө мөнгөний хувьд хэмнэлттэй байх зэрэг олон давуу талтай.

Иймд мэдээллийн санг үүсгэх ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамтай санамж бичиг байгуулан ажиллахаар төлөвлөж байна.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг төрийн зохицуулалтад хамааруулсны ач холбогдол юу вэ?

Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага /ФАТФ/-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол улсыг ФАТФ-аас өгсөн үүрэг даалгаврыг богино хугацаанд биелүүлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо бэхжүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийг онцлон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-аас гаргахаар шийдвэрлэсэн. Энэхүү үйл явдалд Санхүүгийн зохицуулах хорооны үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын зохицуулалт чухал нөлөө үзүүлсэн. Цаашид энэ үр дүнг бататгахын тулд хичээн ажиллаж байна.

Ярилцсанд баярлалаа.




ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АМИНЫ ОРОН СУУЦ БАРИХ ӨРТӨГ, ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТ

Өмнөх нь 1-р нүүрт

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны загвар:



Эх үүсвэр: Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төлөвлөлт (barilga.mn)

Эрчим хүчний хэмнэлттэй барилгыг дотор нь эрчим хүчний хэмнэлттэй барилга, пассив сууц, тэг эрчим хүчний сууц гэж ангилдаг. Ердийн барилгатай харьцуулахад өрхийн хэрэглээндээ цахилгаан болон бусад эрчим хүч бага зарцуулдаг, халаалтад шаардагдах дулааны хэмжээ 70кВт.цаг/м2.жил-ээс бага байх барилгыг эрчим хүчний хэмнэлттэй гэж үздэг. Архитектур төлөвлөлт, барилгын хийц технологи, ахуйн техник гэсэн гурван үндсэн хүчин зүйлийг зохистой, үр ашигтайгаар төлөвлөснөөр барилгыг эрчим хүчний хэмнэлттэй барих боломж бүрдэнэ.

Бага энергийн буюу эрчим хүчний хэмнэлттэй барилгыг дараах байдлаар тодорхойлж болно.

- Барилгын бүх гадаргуу нь маш сайн дулаалгатай;
- Дулаалгын хийц шийдлийг зөв төлөвлөж нягт нямбай гүйцэтгэсэн бөгөөд дулааны гүүр буюу дулааны урсгал үүсэх бүхий л боломжийг хязгаарласан;

- Барилга нь цомхон хэлбэртэй буюу аль болох гадаргуугийн талбай багатай байх;
- Барилгын хашлага бүтээц нь өндөр битүүмжлэлтэй;
- Хяналттай хэрэгцээнд нь таарсан агаар сэлгэлттэй;
- Хийц төлөвлөлтийн аргаар нарны эрчим хүчийг ашиглах боломжийг бүрдүүлсэн;
- Халаалтын болон салхивчийн систем нь уян хатан тохируулгатай;
- Хэрэгцээнд нь таарсан халаалтын зуух, системтэй.

Барилгын төсөв зохиох дүрмийн дагуу барилгын өртгийг цалин, материал, сантехник, цахилгаан, механизм, тээврийн болон шууд бус зардлуудад ангилан, тэдгээрийг дотор нь нэг бүрчлэн ажилбарын тоо, нэгжээр гаргадаг байна.

ӨРТГИЙН ТООЦОО

2019 оны 5 дугаар сарын байдлаар www.barilga.mn-ээс тооцсон тооцооллоор эрчим хүчний хэмнэлттэй 79.42м2 амины орон сууц барих нийт өртөг 93.7 сая төгрөг гэж гарсан. Үүнээс хойших

хугацаанд Ковид-19-ийн нөлөөгөөр барилгын материал, шатахуун гээд материалын зардал 40 хувиар өссөн. Ийнхүү өссөн хэмжээгээр үнэлэн тооцвол 131.1 сая төгрөг болж байна.

Д/д	Ажлын жагсаалт	Нийт үнэ
1	Цалингийн зардал	21,105,000
2	Материалын зардал	58,778,050
3	Сантехникийн зардал	3,400,600
4	Цахилгааны зардал	3,194,500
5	Механизмын зардал	2,700,000
6	Тээврийн зардал	2,500,000
7	Шууд бус зардал	2,000,000
	Нийт зардал	93,678,150

Эх үүсвэр: Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төлөвлөлт (barilga.mn)

САНХҮҮЖИЛТ

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц нь байгаль орчинд ээлтэй гэсэн ангилалд хамаардаг тул ногоон зээлд хамрагдах боломж байдаг. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны хувьд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй жилийн 8 хувийн хүүтэй, арилжааны банкнуудаас санал болгож буй жилийн 12 хувийн хүүтэй зээлүүд байдаг.

Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Голомт банкнуудтай жилийн 8 хувь (%), харин Хасбанк, УБ хотын банк, Капитрон банк, Тээвэр хөгжлийн банк, Ариг банкнуудтай 12 хувийн (%) хүүтэй, 15 хүртэлх жилийн хугацаатай, 120.0 сая хүртэлх төгрөгийн зээл авах боломжтой.

Мөн хөндлөнгийн аудитор таны сууцны эрчим хүчний хэмнэлтийг хэмжиж, баталгаажуулах бөгөөд аудиторын зардлыг /төсөвт өртгийн 2%/ ХасБанк төлнө.

Төслийн шалгуур хангасан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц бариулах зорилгоор энэхүү зээлд хамрагдах боломжтой. Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх гэж буй амины орон сууцыг төслийн шалгуур хангасан, чанартай, туршлагатай барилгын компаниуд батлагдсан зураг, төсвийн дагуу барьж өгөх болно.

КОМПАНИАР БАРИУЛАХ ӨРТӨГ

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьдаг компаниуд барилгын үнийг м.кв-аар үнэлдэг ба дундаж үнэ нь 1,950.0 мянган төгрөгөөс 3,300.0 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна.

ЭНЭ ЗАМ БОЛЖ

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ АНХНЫ СЭНДБОКСЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

2022 оны 7 дугаар сарын 25-ны өдөр Испани, Европын эрх баригчид болон энэ салбарын нэр хүндтэй мэргэжилтнүүд Испанийн засгийн газар болон Европын Комисс Брюссельд болсон арга хэмжээний үеэр хиймэл оюун ухааны (AI) анхны сэндбокс зохицуулалтын орчны туршилтыг танилцуулав. Энэхүү зохицуулалтын орчин нь эрх бүхий байгууллагуудыг хиймэл

оюун ухаан хөгжүүлдэг компаниудад ойртуулж, Европын Комиссын ирээдүйн хиймэл оюун ухааны журмыг (Хиймэл оюун ухааны тухай хууль) хэрэгжүүлэхэд чиглүүлэх шилдэг туршлагыг тодорхойлох зорилготой юм. Ингэснээр хоёр жилийн хугацаанд хууль хэрэгжих боломжтой болно.



Сэндбоксын зохицуулалтын орчин нь шинийг санаачлагч, зохицуулагчдыг холбож, хамтран ажиллах хяналттай орчинг бүрдүүлэх арга зам бөгөөд зохицуулагчид болон шинийг санаачлагчдын хоорондох уг хамтын ажиллагаа нь хиймэл оюун ухааны журмын шаардлагыг дагаж мөрдөх, шинэлэг AI системийг хөгжүүлэх, турших, баталгаажуулах ажлыг хөнгөвчлөх ёстой. Экосистем бүхэлдээ хиймэл оюун ухааны тухай хуульд бэлдэж байгаа ч сэндбоксын зохицуулалтын орчинд ашиглах санаачилга нь дагаж мөрдөхөд хялбар, ирээдүйд шилдэг туршлагын удирдамжийг бий болгоно гэж найдаж байна. Энэхүү үр дүнд нь компаниуд, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэл болон гарааны бизнес эрхлэгчдэд дүрэм журмыг хэрэгжүүлэхэд тусална гэж найдаж байна.

Испанийн засгийн газрын санаачилсан энэхүү сэндбоксын зохицуулалтын орчинд ашиглах туршилт нь ирээдүйн хиймэл оюун ухааны зохицуулалтын шаардлага болон тохирлын үнэлгээ, зах зээлийн дараах үйл ажиллагаа зэрэг бусад шинж чанаруудыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Энэхүү туршилтын ачаар хиймэл оюун ухааны системийн үйлчилгээ үзүүлэгчдийн (хамгаалагдсан хязгаарлагдмал орчинд оролцогчид) хүлээх үүрэг, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх сайн туршлага, удирдамжийг системчлэх болно. Үүний үр дүнд нь журамд заасан хяналтын механизмыг хэрэгжүүлэх үүрэг бүхий эрх бүхий байгууллагуудад хяналт тавихад хэрэгтэй хяналт, дагах журмуудыг багтаасан байна.


Европын түвшний бүх боломжит оролцогчдын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд энэхүү туршилт нь нийт Европын хиймэл оюун ухааны сэндроксын зохицуулалтын орчны туршилтыг дагаж, нэгдэх боломжтой бусад гишүүн орнуудад нээлттэй хэвээр байх ба Хорооноос байгуулсан хиймэл оюун ухаан, бизнесийг дижитал болгох шинжээчдийн бүлгийн хүрээнд Европын холбооны бусад гишүүн орнуудтай хамтран ажиллах болно гэдгээ мэдэгдсэн байна.

Энэхүү сэндроксын зохицуулалтын орчны санхүүжилтийг Испанийн засгийн газарт хуваарилсан сэргээн босголтын сангаас, Испанийн сэргээн босголт, өөрчлөлт, уян хатан байдлын төлөвлөгөө, ялангуяа Испанийн үндэсний хиймэл оюун ухааны стратеги (Төлөвлөгөөний 16-р бүрэлдэхүүн хэсэг) –ээр дамжуулан санхүүжүүлж байна. Туршилтын нийт төсөв

ойролцоогоор гурван жилийн хугацаанд ойролцоогоор 4.3 сая евро байхаар тооцсон байна.

Бүх гишүүн орнууд болон Европын комисст ашиглах боломжтой гарын авлага

Туршилтууд 2022 оны 10-р сараас эхэлж, үр дүнг 2023 оны хоёрдугаар хагаст Европын Холбооны Зөвлөлийг Испани улс зохион байгуулах үеэр нийтлэх болно. сэндроксын зохицуулалтын орчинд цуглуулсан туршлагыг сайн туршлага, хэрэгжүүлэх удирдамж хэлбэрээр танилцуулах ба Бүх гишүүн улсууд болон Европын комисст ашиглах боломжтой бөгөөд хиймэл оюун ухаанд ашиглах цаашдын журмыг хэрэгжүүлэхэд ашиглаж болно.



СУДЛААЧИЙН ИНДЭР

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт П.Байгалмаа, baigalmaa@frc.mn

ХУРААНГУЙ

Дэлхий даяар 130 гаруй Үндэсний баялгийн сан байгаагаас 2020 оны байдлаар 57 улсын 92 Үндэсний баялгийн сан идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байна. Үндэсний баялгийн сангийн хөрөнгө оруулалтын ерөнхий зорилго нь мөнгөөр мөнгө олох явдал бөгөөд түүний ач холбогдол нь ирээдүйн хойч үедээ зориулах үндэсний санхүүгийн хуримтлал бий болгох, эдийн засаг өсөлтийг дэмжих, санхүүгийн аюулгүй байдал, улсын төсвийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн хараат бус байх эдийн засгийн хэрэгсэл бөгөөд нийгмийн том хариуцлагатай байгууллага байж чаддаг оршино. Тухайлбал Үндэсний баялгийн сангийн оруулж буй хөрөнгө оруулалт нь санхүүгийн зах зээлийн хямралын үед дэлхийн томоохон санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн эх үүсвэр болж, эмзэг балансыг бэхжүүлж байдаг. Түүнчлэн сүүлийн 3 жилд Дэлхий нийтийг хамарсан аюулт өвчин, Ковид-19 цар тахлын үед вакцин боловсруулах томоохон хөтөлбөрүүдийг дэмжих, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах эсвэл үндэсний эдийн засаг, нийгмийн онцгой байдлын төлөвлөгөөнд хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Манай улсын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ гэж Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан. Үүний дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын намрын чуулганаар өргөн барихаар төлөвлөсөн байна.

Иймд энэхүү судалгаандаа Үндэсний баялгийн сан гэж юу болох, түүний зорилго, шинж, ангилал, тодорхойлолт, засаглал, бүтэц, тоо, хөрөнгө, хөрөнгө оруулалтын төлөв, ил тод байдлын талаар

тусгаж улмаар дэлхийд үйл ажиллагаа, хөрөнгийн хэмжээгээрээ өндөр, нэр хүнд нь өссөн Норвег, Чили, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй орнуудын Үндэсний баялгийн сангийн хөгжил, зорилго, хөрөнгийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын бодлого, засаглал, өнөөгийн байдал зэргийг харуулж цаашлаад Үндэсний баялгийн сангийн нийтлэг шинж чанарыг агуулсан ижил төстэй Монгол орны баялгийн сангуудын хөгжил, алдаа дутагдлыг үзүүлэхийг зорилгоо.

Уг судалгааг хийхийн тулд Үндэсний баялгийн сан болон дээрх улсын төрийн болон эрдэм шинжилгээний байгууллагуудын албан болон судалгааны эх сурвалжууд, эрдэмтэн судлаачдын бүтээл, нийтлэлийг цахим орчноос цуглуулан уншиж дүн шинжилгээ хийж энэхүү мэдээллээ нэгтгэн бэлтгэсэн болно.

Учир нь Монгол Улс “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.6–д олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно гэж тусгасан бөгөөд Баялгийн сангийн тухай хуулийн төслийг УИХ–ын хаврын чуулганаар өргөн барихтай холбогдуулан далайд дусал нэмэр болох үүднээс энэхүү судалгааг хийсэн нь дэлхийн үндэсний баялгийн сангийн нийтлэг шинж чанар, амжилттай үйл ажиллагаанаас суралцаж, ахиулан биелүүлэхэд бага боловч боломж бүрдэнэ гэж найдаж байна.

УДИРТГАЛ

Үндэсний баялгийн сан сүүлийн жилүүдэд эрчимтэй олширч, олон улсын санхүү, хөрөнгө оруулалт, худалдааны салбарт чухал үүрэг гүйцэтгэгч болсон. Үндэсний баялгийн сан бол төрийн мэдлийн байгууллага бөгөөд тухайн улсын ард түмний өмч юм.

Сан нь: 1. Төр “эзэмшинэ”, 2. Эрх зүйн хэлбэрээрээ төрийн олон нийтийн байгууллага (жишээлбэл, Сангийн яамны нэг хэсэг) эсвэл төрийн өмчит хувьцаат компани байж болно. Эдийн

засгийн хэлбэрээрээ төрийн хяналтад байдаг хөрөнгө оруулалтын хэрэгсэл буюу өөрөөр хэлбэл төрийн сан гэж тодорхойлж болно. 3. Энэ нь төр олон улсын болон гадаад зах зээлд оролцох бүрэн эрхт хөрөнгө оруулагч гэж илэрхийлдэг. 4. Сан нь бүрэн эрхт эзэмшигчидтэй боловч хувийн хэвшилтэй адил үйл ажиллагаа нь явагддаг. 5. Төрийн өмчид харьяалагддаг ч Олон улсын зах зээл дээрх нь арилжааны хөрөнгө оруулалт хийдэг. Сан нь засгийн газартайгаа ойр байж, засгийн газрынхаа зааврын дагуу гадаад дахь хөрөнгө оруулалтаа чиглүүлдэг.

Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаа олон улсын нийтийн эрх зүй гэхээсээ илүү тухайн улсын үндэсний хуулиар зохицуулагдаж, хяналтад байдаг. Сангийн үйл ажиллагааг зохицуулсан олон улсын албан ёсны нийтийн эрх зүй хүрээнд гэрээ, ёс заншил, хуулийн ерөнхий зарчмууд байхгүй.

Үндэсний баялгийн сан нь арилжааны дүр төрхтэй байгууллага бөгөөд түүний оруулах хөрөнгө оруулалт хүлээн авагч орнуудын эдийн засгийн өрсөлдөх чадварыг эрсдэлд оруулахгүй, улс төрийн сэдэлгүй, тусгаар тогтнолд аюул занал учруулахгүй, харин хүлээн авагч орны эрх зүйн актад нийцүүлж үйл ажиллагааг эрхэлж ашиг олох зорилготой болохыг бататгаж нийтээр хүлээн зөвшөөрсөн Сантьягогийн зарчмуудыг сайн дурын үндсэн дээр мөрдөж ажилладаг. Учир нь Сантьягогийн зарчмууд нь тухайн улсын хууль тогтоомжид нийцүүлж үйл ажиллагаагаа эрхлэхийг зөвлөдөг.

Энэхүү судалгааны нэгдүгээр бүлэгт дээр дурдсан аргуудын талаар бататган бичсэн бол хоёрдугаар бүлэгт үйл ажиллагаа, ил тод байдал зэргээр дэлхийд танигдсан 3 орны үндэсний баялгийн сан улмаар Монгол Улс дахь олон улсын үндэсний баялгийн сангийн нийтлэг шинжийг агуулсан сангуудын үйл ажиллагааны талаар судалж тоймлон бичлээ. Судлаачийн зүгээр ямар нэг зөвлөмж, дүгнэлтийг дэвшүүлээгүй болно.

ДЭЛХИЙН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

Үндэсний баялгийн сан гэж юу вэ?

Ихэнх судлаачид Үндэсний баялгийн сан /ҮБС/ бол төрийн өмчит хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр, төв банкны нөөцөөс тусад нь удирддаг, олон улсын зах зээлд институционал санхүүгийн хөрөнгө оруулагч гэж үздэг.

Улс орны эдийн засаг, төсвийг түүхий эдийн үнийн өөрчлөлт, уналтаас хамгаалах, ирээдүй хойч үедээ хөрөнгө хуримтлуулах, төсвийн алдагдлыг нөхөх, эдийн засгийн болзошгүй өглөг,

өр төлбөрийг барагдуулах нөөц хөрөнгийг бий болгох зэрэг өөрийн улсын макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлоготой нийцүүлэн Засгийн газраас ҮБС байгуулдаг.

Тэгэхээр ҮБС гэдэг нь 1. Төр “эзэмшинэ”. 2. Эрх зүйн хэлбэрээрээ төрийн олон нийтийн байгууллага (жишээ нь, Сангийн яамны нэг хэсэг) эсвэл төрийн өмчит хувийн компани байж болно. Эдийн засгийн хэлбэрээрээ төрийн хяналтад байдаг хөрөнгө оруулалтын хэрэгсэл буюу өөрөөр хэлбэл төрийн сан гэж тодорхойлж болно. 3. Энэ нь төр олон улсын болон гадаад зах зээлд оролцох бүрэн эрхт хөрөнгө оруулалтыг илэрхийлдэг. 4. Сан нь бүрэн эрхт эзэмшигчидтэй боловч хувийн хэвшилд үйл ажиллагаа явуулдаг. 5. Төрийн өмчид харьяалагддаг ч Олон улсын зах зээл дээрх засгийн газартайгаа ойр байж, засгийн газрынхаа зааврын дагуу гадаад дахь хөрөнгө оруулалтаа чиглүүлж хөрөнгө оруулалт хийдэг болно.

Сангийн зорилгыг тухайн улс өөрийн эрх зүйн баримт бичигт тодорхой зааж өгсөн байдаг ба олон нийтэд ил тод зарладаг.

Дэвшүүлсэн зорилгоос хамруулж улс орны ҮБС-г ерөнхийдөө дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. Төсвийн тэнцэл ба эдийн засагт макро эдийн засгийн хэлбэлзлийг тогтоох үндсэн зорилгын дагуу байгуулагдсан тогтворжилтын сан. Энэ нь түүхий эдийн болон байгалийн нөөцийн үнийн хэлбэлзлээс үүдэлтэй (Чилийн эдийн засаг, нийгмийн тогтворжилтын сан);
2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг болон эдийн засаг дахь нөөц, бололцоог ирээдүй үеийнхэнд хуваарилах, хуримтлал үүсгэх, түүний байнга өсөн нэмэгдэх санхүүгийн нөөц болгон удирдах зорилгоор болон Голланд өвчний үр дагаврыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэх хадгаламжийн сан. (Абу Даби хөрөнгө оруулалтын газар);
3. Ирээдүйд эдийн засагт учирч болох нийгэм эдийн засгийн хүндрэл, саадыг даван туулах шийдвэрлэх стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор үүсгэсэн болзошгүй нөөцийн сан (Сингапур, БНСАУ, Хятад);
4. Ирээдүйн тэтгэврийн өр төлбөрийг балансжуулах, нөхөн төлөх, тэтгэврийг улсаас нэмэгдүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг нөхөх зорилгоор хуримтлал үүсгэх тэтгэврийн нөөц сан (Австрали, Ирланд, Шинэ Зеланд, Чили);
5. Нийгэм, эдийн засгийн төслүүдийг санхүүжүүлэх эсвэл улс орны үйлдвэрлэлийн өсөлтийг нэмэгдүүлэхэд сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэх Хөгжлийн сан (Арабын Нэгдсэн Эмират /АНЭУ/, Иран).

Хэдийгээр ҮБС–г дээрх байдлаар ангилагдаг ч ихэнх улс орны ҮБС нь давхар бодлогын зорилго агуулсан байдаг. Тухайлбал

энэхүү судалгаанд хамруулсан 3 улсаас Норвег болон Чили улсын ҮБС болно.

Хүснэгт. Судалгаанд хамрагдсан улс орны ҮБС–гийн зорилго

Эх үүсвэр	Улс/Сангийн нэр	Бодлогын зорилго			
		Тогтворжилтын сан	Хадгаламжийн сан Хойч үедээ хуримтлал	Ирээдүйн тэтгэвэр	Болзошгүй нөөцийн сан /валютын нөөц/
Газрын тос ба байгалийн хий	<u>Норвег</u> : Засгийн газрын тэтгэврийн сан		X	X	
Бусад ашигт малтмалын нөөц	<u>Чили</u> : Эдийн засаг, нийгмийн тогтворжуулах сан ба Тэтгэврийн нөөц сан	X		X	
Засгийн газар / валютын нөөц	<u>Сингапур</u> : Хувийн хязгаарлагдмал GIC /GIC Private Limited/				X

Эх үүсвэр: IFSWF

Үндэсний баялгийн сангийн тодорхойлолт

ҮБС гэсэн нэр томъёог анх 2005 онд Андрэй Розанов гэх судлаач Төв банкны сэтгүүлд Улс үндэстний баялгийг хэн эзэмшдэг вэ? гэсэн нийтлэлд ашигласан бөгөөд уламжлалт нөөцийн менежментээс бүрэн эрхт баялгийн менежмент рүү шилжихийг тайлбарласан.

Америкийн нэгдсэн улсын /АНУ/–ын Сангийн яам ҮБС сан нь “Засгийн газрын хөрөнгө оруулалтын санг гадаад валютын нөөцийн ашгаас санхүүжүүлдэг. Засгийн газрын ашгийн төлөө хөрөнгө оруулалт хийж олсон мөнгөний хуримтлал” гэжээ.

Бортолотти, Фотак, Меггинсон, Миракки нар ҮБС нь бие даасан, зохицуулалтгүй усан сан юм. Түүнийг хөрөнгө оруулалтын

мэргэжилтнүүд удирддаг бөгөөд сангийн хөрөнгөөр ихэвчлэн нээлттэй хувьцаат компаниудын хувьцааг их хэмжээгээр авдаг гэсэн.

Хэдийгээр энэ хоёрын тодорхойлолт зөв мэт болох ч эрдэмтэн Ашбай Х.Б. Монк нь илүү оновчтой тодорхойлолтыг өгсөн. Тэрээр гол нь сангийн өмчлөл, хариуцлага ба ашиг хүртэгчид байдгийг тодорхойлсон.

Сантьягогийн олон улсын конвенц 2008 онд албан ёсоор ҮБС–гийн нэгдсэн ойлголтыг “Үндэсний баялгийн сан гэдэг нь засгийн газрын эзэмшилд байдаг тусгай зориулалтын хөрөнгө оруулалтын зохицуулалтын сан юм” гэж томъёолсон болно.

Үндэсний баялгийн сангийн тоо

ҮБС–г улс орон бүр өөр өөр нэрлэх хэдий ч өмнө энэхүү судалгааны 1.1–т дурдсанчлан, төр эзэмшдэг, макро эдийн засгийн бодлогыг дэмждэг, гадаад валютын нөөц, байгалийн баялгийн экспортын орлого, төсвийн илүүдэл, хувьчлалаас орлого төвлөрүүлдэг, орлогоо иргэддээ тэгш хүртээмжтэй хуваарилдаг зэрэг нийтлэг шинжийг агуулсан байна. ҮБС нь санхүүгийн хөрөнгө болох хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө, үнэт металл гэх мэт эсвэл хувийн зэрэг алтернатив хөрөнгө оруулалт хийдэг.

Анх 19–р зууны дундуур тодорхой төрийн үйлчилгээг санхүүжүүлэх зорилгоор АНУ–ын муж улсад сангууд байгуулагдаж байсан. Харин улс орныхоо төлөө байгуулсан

анхны сан бол Кувейтийн хөрөнгө оруулалтын газар /Kuwait Investment Authority/ бөгөөд 1953 онд газрын тосны орлогоор байгуулсан түүхий эдийн сан юм. Энэ цаг үеэс хойш 70–аад оны үед Ойрх Дорнодын орнуудад, 80–аад оны үед Япон, Хятад зэрэг орнуудад, сүүлийн жилүүдэд хөгжиж буй орнууд ихээр байгуулагдаж байна.

2020 оны байдлаар дэлхийн хэмжээнд нийтдээ 130 гаран ҮБС байна. Center for the Governance of Chance–ээс нийтэлсэн ҮБС–гийн 2020 оны тайланд 2020 онд 57 улсад Төрийн эзэмшлийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүд болох 92 ҮБС идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж тэмдэглэсэн байна.

Зураг. Дэлхийн үндэсний баялгийн сан



Эх сурвалж: Үндэсний баялгийн сангийн тайлан 2020 он

ҮБС–гийн хөрөнгө оруулалтын ерөнхий зорилго нь мөнгөөр мөнгө олох явдал бөгөөд түүний ач холбогдол нь сангийн хөрөнгийг өсгөөд зогсохгүй улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжих хэрэгсэл болгодогт оршино.

Түүнчлэн сангийн хөрөнгө оруулалт нь санхүүгийн зах зээлийн хямралын үед дэлхийн томоохон санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн эх үүсвэр болж, эмзэг балансыг бэхжүүлж байдаг.

Тухайлбал: улс орны ҮБС–ууд Ковид–19 цар тахлын үед вакцин боловсруулах томоохон хөтөлбөрүүдийг дэмжих, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах эсвэл үндэсний эдийн засаг, нийгмийн онцгой байдлын төлөвлөгөөнд хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү яаралтай тусламжийн төвлөрөл, дэлхийн түгжрэлийн тодорхойгүй байдал нь улс орны ҮБС–гийн 2019 оны 7 дугаар сарын 01–ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын хооронд төрийн өмчит сангийн гүйлгээний нийт дүн 43 тэрбум ам.доллар хүртэл буурсан байна.

САНГИЙН ХӨРӨНГӨ

Дэлхийн Үндэсний баялгийн сангийн хүрээлэнгийн тодорхойлсноор улс орны ҮБС–гийн хөрөнгө нь төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц болон төсвийн илүүдэл, байгалийн баялгийн экспортын орлого, Засгийн газрын шилжүүлэг, хувьчлалын орлого зэргээс бүрддэг гэжээ.

ҮБС–гийн санхүүжилтийн хэлбэрүүдийг авч үзвэл:

- Төрийн мэдлийн ашигт малтмалын уурхайн экспортоос \Ботсвана, Кувейт, Чили, Эмират\;
- Уул уурхайн экспортын татвараас \Орос, Аляска\;
- Санхүүгийн илүүдэл хөрөнгөнөөс \БНСУ\;
- Тэтгэврийн сангаас \Франц, Ирланд, Шинэ Зеланд\;
- Төв Банкны нөөцөөс \Хятад, Сингапур\;
- Өмч хувьчлалын орлогоос \Австрали, Малай\.

Санд улсын төсвөөс жил бүр шилжүүлдэг санхүүжилтийн хэмжээ нь засгийн газрын төсвийн илүүдэл/алдагдалтай


нягт уялдаатай байдаг бөгөөд жилийн үйл ажиллагааны төсөвт суулгах эсхүл хууль тогтоомжид тогтоосон хэмжээгээр тодорхойлдог.

ҮБС–гийн хөрөнгийг улс орнуудад ихэвчлэн төв банк нь удирддаг. Сан нь хувьцаа, бонд, үнэт металл, үл хөдлөх хөрөнгө болон бусад төрлийн санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө байршуулж өгөөж хүртэх хэлбэрээр ажилладаг.

Сангийн хөрөнгө нь Засгийн газрын мэдэлд байдаг тул гаднаас олсон ашиг засгийн газарт буцаж очих бөгөөд Засгийн газраас олгосон бүрэн эрхийн хүрээнд ашиг хүртэх зорилгоор Засгийн газрын ашиг сонирхлын дагуу хөрөнгө оруулалт хийгддэг.

Дэлхийд нийт хөрөнгийн хэмжээгээр эхний 100–д жагсдаг үндэсний баялгийн сангуудын хөрөнгө 2020 оны байдлаар 9.2 их наяд доллароор хэмжигдэж байна. Нийт ҮБС–гийн санхүүжилтийн эх үүсвэрийн 70 орчим хувь нь байгалийн баялаг, газрын тосны орлогоос бүрдэж байна.

Зураг. Хөрөнгийн хэмжээ



Эх үүсвэр: http://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_sovereign_wealth_funds

ҮБС–гийн хөрөнгийн хэмжээгээр нь жагсаасан жагсаалтын эхний аравт жагсдаг Норвегийн Засгийн газрын тэтгэврийн сан /Норвег/, Абу Дабигийн хөрөнгө оруулалтын газар /Арабын нэгдсэн Эмират улс/, Кувейтийн хөрөнгө оруулалтын газар /Кувейт/, Улсын хөрөнгө оруулалтын сан /Саудын Араб/, Дубайн хөрөнгө оруулалтын корпорац зэрэг сангуудын хөрөнгө оруулалтын гарал үүсэл нь газрын тос, байгалийн хийн экспортын орлогоос бол Хятадын хөрөнгө оруулалтын корпорац /Хятад/, Мөнгөний эрхлэх газрын хөрөнгө оруулалтын багц /Хонг Конг/, GIC хувийн хязгаарлагдмал /Сингапур/, Temasek Холдингс /Сингапур/, Нийгмийн хамгааллын сангийн үндэсний зөвлөл /Хятад/ зэрэг сангуудын хөрөнгийн гарал үүсэл нь түүхийн эдийн бус нөөцөөс бүрдсэн.

ҮБС–гуудаас Норвегийн Засгийн газрын тэтгэврийн сан ойролцоогоор 1,365.0 тэрбум доллар, Хятадын хөрөнгө оруулалтын корпорац 1,222.0 тэрбум долларын хөрөнгөтэйгөөр дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд удаах нь Абу Дабигийн Хөрөнгө оруулалтын газар бөгөөд 649.0 тэрбум доллар, Сингапурын Хөрөнгө оруулалтын корпорац 545 тэрбум доллар, Temasek Holdings Ltd 484.0 тэрбум долларын тус тус хөрөнгөтэйгөөр жагсаалтын эхний 5 байранд тэргүүлж байна.

Сангийн хөрөнгө оруулалтын төлөв

ҮБС–гууд эх орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд том үүрэг хариуцлага хүлээдэг. Улс орны сангийн хөрөнгө оруулалт сүүлийн 50 жилийн хугацаанд эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн.

Хөрөнгө оруулалтын үндэслэл нь сан бүрд өөр өөр байдаг ч хөрөнгө оруулалтын үндсэн шалтгаан нь санхүүгийн өгөөж хүртэх гэж хэлдэг.

ҮБС–гийн гол баримталдаг зүйл бол эх орныхоо засгийн газар, иргэд болох оролцогч талуудад ашиг орлого олж өгөх боломжуудад хөрөнгө оруулалт хийхэд оршино.

Тиймээс Бэк ба Фидора (2008) ҮБС–гууд урт хугацаанд хамгийн их ашиг орлого өгдөг газруудад мөнгөө байршуулдаг гэжээ.

Балдинг судалгаандаа ҮБС ихэвчлэн хувийн хэвшилтэй адил хөрвөх чадвар сайтай хувьцаанд хөрөнгө оруулалт хийдэг гэж дүгнэсэн байдаг.

Улс бүр өөрийн улсын ҮБС–гийн тухай эрх зүйн баримт бичигтээ сангийн хөрөнгийг зөв удирдахад зориулж хараат бус бодлогын удирдлага, санхүүжилт, хөрөнгө оруулалтын

төрөл, хувь хэмжээг хязгаарлах, эрсдэлийн хэлбэлзэл, сангийн бүтэц, үүрэг, хариуцлага, ил тод байдлыг хангах зэрэг хяналт, зохицуулалттай холбоотой асуудлыг тусгасан байдаг.

Ихэнх улс оронд ҮБС нь дотооддоо хөрөнгө оруулалт хийх хориотой байдаг. Жишээлбэл: Азербайжан, Чили, Норвег гэх мэт. Ингэж хориглох гол шалтгаан нь дотоодын хөрөнгө оруулалт хийх нь сангийн эдийн засгийн ашиг, өгөөжтэй ажиллах зорилготой зөрчилдөх үр дагавартай гэж үздэг. Учир нь дотоодын хөрөнгө оруулалт нь нутгийн хөрөнгийг өсгөж, валютын ханш чангаруулж экспортын өрсөлдөх чадварыг бууруулж болзошгүй гэж үздэг байна. Харин дотоод хөрөнгө оруулалтыг зөвшөөрдөг улс нь дотоодын хөгжлийн зорилгын хүрээнд (Иран), аль эсвэл нарийвчилсан стратегийн хүрээнд хувийн хэвшлийн чадавхыг сайжруулахад чиглэдэг (Кувейт).


ҮБС–гууд 2012 онд хөрөнгийнхөө ердөө 9 хувийг хувийн зах зээлд оруулдаг байсан бол 2017 оны эцэст үл хөдлөх хөрөнгө эсвэл дэд бүтцээс тогтвортой, өндөр хөрөнгө оруулалтын орлого олохын тулд энэ үзүүлэлтээ 30 хувь хүртэл өсгөсөн харин үлдсэн 70 хувийг тогтмол орлого (30.0 хувь) болон хөрөнгийн биржид бүртгэлтэй (40.0 хувь) хувьцаа, бондод тараан байршуулсан байна.

Сангууд компанийн хувьцаа 1.0 хувь ба түүнээс доош байхад тэдний байр суурь хэвийн, энгийн гэж үздэг хэдий ч эзэмшлийн эрхээ ашиглах үед урт хугацааны турш өгөөж хүртэх хөрөнгө оруулалтад илүү анхаардаг.

IE–ын 2020 оны тайлангаас харвал ҮБС нь эрчим хүч, хүнсний гээд өөр эх үүсвэрийг хайж, технологид суурилсан компаниудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, түүнчлэн АНУ, Хятад, Энэтхэг, Их Британи гэсэн дөрвөн том зах зээлд анхаарлаа хандуулж байна. Үл хөдлөх хөрөнгө (зөвхөн үйлдвэр төдийгүй оффис, зочид буудал) болон дэд бүтэц (зөвхөн харилцаа холбоо төдийгүй байгалийн хий, зам тээвэр) нь сангуудын анхаарал татахуйц зорилтот салбар нь хэвээр байна.

Мөн сүүлийн жилүүдэд ҮБС–гуудын ногоон хөрөнгө оруулалт их хийж байна. Тухайлбал 2019 онд сангууд ногоон хөрөнгө оруулалтад оруулсан нийт дүн 11.0 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь нийт хөрөнгийнх нь 0.15 хувиас бага боловч сангуудын шууд хөрөнгө оруулалтын дүнгийн бараг 8 хувийг эзэлж байгаагийн ихэнх хувийг сэргээгдэх эрчим хүчний компаниуд байна (Зураг 3–ыг үз).

Зураг. Ногоон хөрөнгө оруулалт



Эх үүсвэр: Сапарй, J., & Santiso, J. (Eds.)

Түүнчлэн Норвег, Шинэ Зеланд, Францын ҮБС-гууд хүлэмжийн хийн ялгаруулалт өндөртэй компаниудад 2.9 тэрбум ам.доллараар хэмжигдэх хөрөнгийг хөрөнгө оруулалтын багцасаа хасжээ.

АНЭУ, Марокко, Сингапур, Хятад, Саудын Араб зэрэг улсын ҮБС-гууд хөгжиж буй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын ногоон дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийхэд анхаарал хандуулж байна.

Ерөнхийдөө сангууд 2019 онд ногоон өрийн платформ (4.3 тэрбум ам.доллар), сэргээгдэх эрчим хүчний компаниуд болон төслүүдэд хөрөнгө оруулах (3.5 тэрбум ам.доллар), ногоон дэд бүтцийн санд (2.2 тэрбум ам.доллар) оролцох замаар ногоон хөрөнгөд хөрөнгө оруулалт хийсэн. Тэд мөн эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг гаргаж, махгүй бургер үйлдвэрлэдэг, лабораторид ургуулсан арьс боловсруулдаг гарааны бизнесүүдийг дэмжиж байна.

ДОЛОО. ЭХ СУРВАЛЖ

- Balding, C. (2008). A portfolio analysis of sovereign wealth funds, <http://ssrn.com/abstract=1141531>
- Beck, R, & Fidora, M. (2008). The impact of sovereign wealth funds on global financial markets. *Intereconomics*, 349–358.
- Chilean Financial Committee. (2008). Annual report 2008. Retrieved February 9, 2010, http://www.minhda.cl/english/fondos_soberanos/informe_anual.php#
- Norges Bank Investment Management. (2009, December 31). Latest benchmark. <http://www.nbim.no/en/Investments/benchmark-portfolio/lat-es-benchmark/>
- Sovereign Wealth Institute. (2008). Social and economic stabilization fund– chile. <http://www.swfinstitute.org/fund/chile.php>
- James Chen Investopedia /2019/ Economic and Social Stabilization Fund.
- INTERNATIONAL WORKING GROUP OF SOVEREIGN WEALTH FUNDS, <https://www.ifswf.org/sites/default/files/2010%20Kuwait%20Meeting%20-%20Kuwait%20Declaration.pdf>
- СҮЙРҮҮЛДЭГ БИШ, ХӨГЖҮҮЛДЭГ САНГИЙН ТУХАЙ... , <https://ganaa.mn/2019/09/01/wqefafalgjufuduud/>
- Норвегийн баялгийн сангийн туршлагаас авах, гээх зүйлс, <https://www.trends.mn/n/8771>
- Natural resource funds, <https://resourcegovernance.org/natural-resource-funds>
- Б.Батмагнай: Баялгийн сангийн хөрөнгөөр дотоодын төслүүдээ санхүүжүүлнэ, <http://www.erdenesmongol.mn/index.php?view=article&type=item&val=579>
- Sovereign wealth funds, new challenges for the Caspian countries, <https://resourcegovernance.org/sites/default/files/documents/swfs-caspian-countries1.pdf>
- International Forum of Sovereign Wealth Funds Santiago Principles: 15 Case Studies /2014/, https://www.ifswf.org/sites/default/files/SantiagoP15CaseStudies1_0.pdf
- SIC Private Limited, <https://www.ifswf.org/member-profiles/government-singapore-investment-corporation>
- Report on the management of the government's portfolio 2019/2020, <https://www.ifswf.org/sites/default/files/annual-reports/GIC-Report-2019-20-1.pdf>
- Trust, Legitimacy, and Governance, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1134862
- How Can Sovereign Wealth Funds be Encouraged to Go Green? <https://www.greenfinanceplatform.org/blog/how-can-sovereign-wealth-funds-be-encouraged-go-green>
- Pension reserve fund, quarterly executive report as of March 2020, <file:///C:/Users/baigalmaa/Downloads/2020%20Q1%20FRP%20Report.pdf>
- Economic and social stabilization fund, quarterly executive report as of March 2021, [file:///C:/Users/baigalmaa/Downloads/2021%20-%20Q1%20ESSF%20Report%20\(1\).pdf](file:///C:/Users/baigalmaa/Downloads/2021%20-%20Q1%20ESSF%20Report%20(1).pdf)
- Santiago principles, https://en.wikipedia.org/wiki/Santiago_Principles
- Rankings by Total assets, <https://www.swfinstitute.org/fund-rankings/sovereign-wealth-fund>
- Хөгжлийн шалгарал, <https://business.mn/blog/2020/12/29/hugjiliin-shalgaral/>
- Баялагийн сан ба төрийн оролцоо, дэлхийн жишиг www.dorgio.mn
- Монгол Улсад 22 төрлийн тусгай сан байна, <https://ikon.mn/n/1rnu>
- Баялгийн сангийн тухай, <http://www.iltod.gov.mn/?p=2824>
- Баялагийн сан, баялгийн үр ашгийг иргэдэд хүртээх нь, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Дэд сайд Д.Загджав, 2019, <https://cabinet.gov.mn/wp-content/uploads/uul-uurhai.pdf>
- Үндэсний баялгийн сан байгуулна, 2021, <https://www.n24.mn/a/4273>
- Баялгийн сангийн шинэ хувилбар “мэндлэх” –ээр айсуй, 2019, <http://www.erdenesmongol.mn/index.php?view=article&type=item&val=574>
- Баялагийн сангийн нэг хувилбар, <http://eagle.mn/r/8879>
- Монгол улсын баялгийн сангуудын эдийн засаг дахь нөлөө, <https://www.mongolbank.mn/documents/news>
- Монгол улсын 2018, 2020 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт, <https://mof.gov.mn>
- Хууль, тогтоомжууд:**
- Монгол Улсын Үндсэн хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Хүний хөгжлийн сангийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Ирээдүйн өв сангийн тухай хууль
- УИХ-ын 2020 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2 дугаар тогтоол
- Алсын хараа 2050
- Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №13

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ФИНТЕК ГЭЖ ЮУ ВЭ?

“Финтек” нь Financial technology гэсэн холбоо үгийн товчлол бөгөөд уламжлалт санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлт, хэрэглээг сайжруулах, автоматжуулахад чиглэсэн технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн юм.

ФИНТЕКИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО

нь Технологийн дэвшил, инновацийн шийдэл болох хиймэл оюун ухаан, блокчэйн, их өгөгдөл, үүлэн технологи дээр тулгуурлан хөгжүүлсэн программ хангамж, аппликэйшн, алгоритм, процесс, бизнесийн загваруудаар дамжуулан уламжлалт санхүүгийн үйлчилгээг хамгийн бага зардлаар, хурдан шуурхай, хүртээмжтэй хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх юм.



Финтекийн хөгжлийн түүх

Судлаачид финтекийг хөгжлийнх нь хувьд 4 үе шатанд хуваан авч үзэж байна.



Сүүлийн жилүүдэд хөгжиж байгаа орнуудын дундаас финтекийн хэрэглээгээр тэргүүлж буй Хятад, Энэтхэг зэрэг улсуудын хэрэглээний түвшинг харуулсан.

2008 оноос өнөөг хүртэл: Криптовалют, мобайл төлбөрийн шийдэл, краудфандин платформ, P2P төлбөрийн системийг нэвтрүүлсэн.

1967–2008 он: Анхны ATM, NASDAQ, SWIFT, цахим худалдаа, онлайн банкны үйлчилгээ, гар утасны хэрэглээ, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийг зах зээлд нэвтрүүлсэн.

1886–1967 он: Телеграф, морзын код, трансатлантик кабель, федвайр зэрэг тухайн үеийн технологийг ашиглан анхны цахим технологиор мөнгө шилжүүлэх системийг идэвхжүүлсэн.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Цуврал №13

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ФИНТЕК БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Финтекийн үйлчилгээг олон улсын түвшинд нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах чиглэлээр түлхүү хөгжүүлж байна

1	Хиймэл оюун ухаан болон бот		Утасны автомат хариулагч болон робот технологи ашиглан санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ.
2	Краудфандинг		Төсөл болон бизнесийг санхүүжүүлэх зорилгоор онлайн платформоор дамжуулан олон тооны хувь хүнээс хөрөнгө оруулалт татах технологи.
3	Дижитал банк		Банкны уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, зайнаас санал болгодог.
4	Гар утаснаас санхүүгийн үйлчилгээ		Интернэт орчинд хөдөлгөөнт төхөөрөмж (гар утас, таблет)-ийг ашиглан санхүүгийн үйлчилгээ авах технологи.
5	Нууцлалын аюулгүй байдал, биомитрик		Царай, хурууны хээ, дуу хоолой болон биеийн бусад хэсгийг таниулж, санхүүгийн гүйлгээ хийх технологи.
6	Блокчэйн болон криптовалют		Байршлаас үл хамааран төвлөрсөн сервер удирдлагын функцгүйгээр өөр хоорондоо шууд холбогдож арилжаа хийх технологи.
7	P2P зээл		Гуравдагч этгээдийн зуучлалгүйгээр бие биетэйгээ шууд харилцаж, зээл авах төвлөрсөн бус платформ.
8	Валют арилжаа		Цахим валютын бирж нь улс хооронд болон дотооддоо валют солилцох интернетэд суурилсан платформ.
9	Хөрөнгө оруулалт		Хувьцаа, бонд болон бусад төрлийн хөрөнгө оруулалтын цахим арилжаа.
10	Хөнгөлөлт урамшууллын систем		Худалдааны байгууллагууд байнгын үйлчлүүлэгчиддээ зориулж хөнгөлөлт, урамшуулал олгох дижитал технологи.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №13

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ФИНТЕК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД:

Давуу тал:



Сул тал:

1

Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 24 цагийн турш үйлчилгээ авах боломжтой, хугацаа, зардал хэмнэдэг, үйлчилгээний шимтгэл бага.

1

Хувь хүний мэдээлэл, гүйлгээний нууцлал алдагдах, кибер халдлагад өртөх эрсдэлтэй, зөвхөн интернет орчинд ажилладаг.

2

Залилан мэхлэлт, луйврын эрсдэлийг бууруулдаг.

2

Зохицуулалтгүйн улмаас хэрэглэгчийг хохироох магадлалтай.

3

Хүссэн үедээ арилжаанд оролцох боломжтой, хөрөнгө оруулагчийн хувьд сонголт ихтэй, ил тод.

3

Гүйлгээг буцаах боломжгүй, хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн баталгаа муу.

4

Хэрэглэхэд хялбар, хүртээмжтэй, олон талт, хөрвөх чадвар өндөр.

4

Зарим тохиолдолд ямар дансруу нэвтрэх болон гүйлгээ хийх мөнгөн дүнгийн хязгаарлалт тавьдаг.

5

Үйл ажиллагааг нь хянах, төсөл болон бизнесийг сайжруулах чиглэлээр саналаа илэрхийлж, хамтран оролцох боломжтой.

5

Хүссэн мэдээлэл, үйлчилгээгээ бүрэн авах боломж, хэрэглэгчийн нэмэлт хүсэлтийг шийдвэрлэх байдал хомс, мэргэжилтнээс зөвлөгөө авах боломжгүй.



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

СТАТИСТИКИЙН ТООЦООЛЛЫН СУУРЬ ОЙЛГОЛТУУД ХИЧЭЭЛ №7



ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА В.ЭНХБААТАР

ЖИГНЭСЭН ДУНДАЖ

Жигнэсэн дундаж нь бүлэг тооны гишүүдийн тухайн бүлэгт эзлэх жин, ач холбогдлыг агуулсан үзүүлэлт юм. Жигнэсэн дунджийг арифметик болон геометр гэсэн хоёр аргаар тооцоолдог.

Жишээ нь: Та хэд хэдэн удаа ялгаатай үнээр хувьцаа худалдан авсан гэж төсөөлье. Худалдан авалт бүрд тэнцүү тооны хувьцаа авсан гэж төсөөлбөл нэгж хувьцааны дундаж үнэ бүх худалдан авалтын арифметик дундаж байна. Гүйлгээ бүрд худалдан авсан хувьцааны тоо адилгүй бол дээрх тооцоолол ач холбогдолгүй. Түүнчлэн, гүйлгээ болгон адил хэмжээтэй ч зарим нь худалдан авалт биш зарсан бол мөн дээрх тооцоолол ач холбогдолгүй болно. Тэгвэл тухайн гүйлгээг үнийн дүнгээр нь нийт худалдан авалтад жигнэвэл, багаасаа жингээр илүү томоохон дүнтэй гүйлгээний дундаж үзүүлэлт үнэд нөлөөлөх нь мөн илүү байна. Тооцоололд худалдан авалтыг (+) нэмэхээр, худалдсаныг (-) хасахаар тэмдэглэнэ.

$$\text{Жигнэсэн дундаж} = \frac{\sum (\text{хэмжээ} \times \text{жин})}{\sum (\text{жин})}$$

Олон улсын валютын арилжаанд, банкнууд тухайн өдрийн дундаж ханшийг арилжааны төгсгөлд нийтэлдэг. Энэ нь тухайн өдрийн арилжаанд ашиглагдсан, тухайн валютын “жигнэсэн дундаж” ханш бөгөөд ханш нь валют авсан, зарсан гүйлгээ бүрийн ханш, харин жин нь уг гүйлгээ бүрд хамаарах валютын хэмжээ юм.

Академик сурах бичиг, статистикийн тооцоололд “жигнэсэн дундаж”-ийг ихэвчлэн “голч” гэж нэрлэдэг. Тухайлбал, тухайн өдрийн валютын арилжаанд суурилсан ханшийн мэдээ, оюутны сурлагын чанарын үзүүлэлт “голч” оноо нь жигнэсэн арифметик дундаж бодох аргаар тооцоологддог.

Жишээ нь: Дилер гадаад валютын арилжаагаар дараах гүйлгээг (EUR/CHF) хийсэн гэж төсөөлье.

		ханш
зарсан	€4,000,000	1.2723
авсан	€1,000,000	1.2732
авсан	€5,000,000	1.2729

Дилерийн арилжааны дүн ямар байх вэ? Арилжааны дундаж ханш хэд вэ?

Дундаж ханш нь арилжаа бүрийн ханшийг, арилжаа бүрийн валютын хэмжээгээр “жигнэсэн дундаж” юм.

		ханш	
	-€4,000,000	x 1.2723 =	-5,089,200
	+€1,000,000	x 1.2732 =	+1,273,200
дүн	+€5,000,000	x 1.2729 =	+6,364,500
	+€2,000,000		+2,548,500

Дундаж ханш: 2,548,500 / €2,000,000 = 1.27425

Жигнэсэн дундаж ханш нь 1.27425, бөгөөд дилерийн арилжааны дүн €2,000,000 –г 1.27425 ханшаар худалдан авсан байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПЛАЙНСЫН АЖИЛТАН ГЭЖ ХЭН БЭ?

Комплайнсын ажилтан нь компанийн бүхий л үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэн явагдаж буй эсэхэд хяналт тавих үүрэгтэй бөгөөд зөвхөн хуулиар хязгаарлагдах бус компанийн дотоод журам, дүрэм, стандартад компанийн үйл ажиллагаа нийцэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй. Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх удирдлага, комплайнсын ажилтангүйгээр холбогдох хууль тогтоомжийг зөрчих, хуулийн хариуцлага хүлээхээс гадна компанийн нэр хүндэд хохирол учрах эрсдэлтэй.

ADAC буюу Германы автомашинтай холбоотой 2014 оны дуулиан, саяхан үүссэн WIRECARD-тай холбогдох асуудал зэрэг олон дуулиан шуугианаас үүдэлтэйгээр жижиг дунд бизнесээс эхлээд томоохон корпорацууд хүртэл комплайнсын ажилтандаа ихээхэн итгэл найдвар тавьж ажиллах шаардлагатайг харуулж байна.

Комплайнсын ажилтан хууль тогтоомжийн зохицуулалтын стандартуудыг дагаж мөрдөх, дотоод шинжээчийн үүргийг гүйцэтгэж, аливаа шинэчлэлтэд соргог байж, комплайнсын үйл явц бүрэн хэрэгжиж байгаад хяналт тавьдаг. Тийм учраас комплайнсын ажилтнууд маш чухал үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд хөдөлмөрийн зах зээлд өндөр эрэлттэй байна.

Комплайнсын ажилтан юу хийдэг вэ?

- Компанийн үйл ажиллагаа хууль, эрх зүйн зохицуулалт, ёс зүйн хэм хэмжээний хүрээнд явагдаж буй эсэх, түүний хэрэгжилтийг хянаж, хангуулах;
- Судалгаа шинжилгээ, мониторинг тогтмол хийснээр байгууллагын жигд үйл ажиллагааг хангахад хувь нэмэр оруулах;
- Хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар мэдээллээр хангах, сургалт хийх;
- Байгууллагын удирдлага, ахлах түвшний менежер хоорондын холбогч байх;
- Эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх.

Комплайнсын ажилтан нь байгууллагын удирдлага болон менежерүүдийг холбох гүүр болдог бөгөөд бусад асуудал хариуцсан нэгжүүдийн ажил үүргийн хуваарьтай нийцүүлэн холбогдох нэгж болон удирдлагын хоорондох мэдээллийн урсгалыг зохицуулах гол ажилтан болдог.

Тэрээр бие даасан хараат бус буюу төлөөлөн удирдах зөвлөлд харьяалагдан ажлаа шууд тайлагнадаг байх нь хамгийн тохиромжтой загвар юм. Энэ нь удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах баталгаа нь болдог.

Комплайнсын хяналт нь тухайн байгууллагын үйл ажиллагаа эрхэлж буй бүх салбарт хамаарах цогц асуудал бөгөөд олон төрлийн хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаарддаг тул комплайнсын ажилтан ажил, үүргийн хувьд ихээхэн ачаалалтай байдаг. Иймд комплайнсын асуудал эрхэлсэн нэгж байгуулах нь комплайнсын хяналтын удирдлагын тогтолцоог бий болгож, эрсдэлийн үнэлгээ, сургалтыг гүйцэтгэхэд нь илүү боломжийг олгодог байна.

Комплайнсын ажилтан дээд удирдлагатай шууд харилцаж, бизнесийн шийдвэр гаргахад нь зөвлөх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гаднын зөвлөхөөс ялгаатай нь хууль тогтоомжийн дагуу шийдвэр гаргахын зэрэгцээ бизнесийн зорилгодоо хүрэх шийдлийг эрэлхийлэгч болдог байна.

Хэрэв компани комплайнсын хяналтыг шинээр нэвтрүүлж байгаа тохиолдолд юуны өмнө комплайнсын удирдлагын тогтолцоог бий болгож, компанийн ажилтанд өгсөн бэлэг дурсгалыг бүртгэж, хянан шийдвэрлэх тогтолцоог эхлэн бүрдүүлж, “шүгэл үлээгч”-ийг дэмжсэн шууд мэдээлэл авах нөхцөлийг хангах хэрэгтэй. Комплайнсын хяналтын удирдлагын тогтолцоо нь дээрх системийн хяналт болон зохион байгуулалтыг хариуцдаг.

Аль ч тохиолдолд компанид учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, тодорхойлох, комплайнсын эрсдэлийг даван туулах, түүнээс зайлсхийх талаар санал боловсруулах, журам, зааврыг боловсронгуй болгох, шаардлагатай тохиолдолд нэмэлт хүний нөөцийг бүрдүүлэх нь комплайнсын ажилтны үүрэг юм.

Үргэлжлэл бий...

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

КАНАДЫН ИНФЛЯЦ СҮҮЛИЙН 40 ЖИЛД БАЙГААГҮЙ ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЧЭЭ.



Тус улсын хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеийнхээс 7.7 хувиар өссөн нь 1983 оны 1 дүгээр сараас хойших инфляцын дээд түвшинд хүрсэн байна. Шатахууны үнэ 12 орчим хувиар нэмэгдсэн нь инфляцын өсөлтөд ихээхэн нөлөөлжээ.

Мөн жижиглэнгийн хүнсний барааны үнэ өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар, хүнсний тосны үнэ 30 хувиар тус тус өссөн нь түүхэн дээд үзүүлэлт болсон байна.

Ажиллах хүчний судалгааны мэдээллээс харахад Канадад цагийн дундаж орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар өссөн байгаа нь бараа бүтээгдэхүүний үнэ цалингаас хурдан өсөж буйг харуулж байна.

ДОЛООГИЙН БҮЛГИЙН ОРНУУД 600 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ДҮН БҮХИЙ ДЭД БҮТЦИЙН САН БАЙГУУЛНА.

АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден Германд эхэлсэн Долоогийн бүлгийн дээд хэмжээний уулзалтад оролцох үеэр “Долоогийн бүлгийн орнууд дэлхийн ядуу, буурай орнуудын дэд бүтцийг санхүүжүүлэхэд зориулж 600 тэрбум орчим ам.доллар босгоно” гэж мэдэгдсэн.



Энэхүү төлөвлөгөө нь БНХАУ-ын “Бүс ба Зам” санаачилгыг сөрөх зорилготой гэж мэргэжилтнүүд үзсэн ба тус санаачилгаас ялгаатай нь энэхүү хөтөлбөрийн санхүүжилтийг голчлон хувийн хөрөнгө оруулагчдаас авах юм. Санхүүжилтийг буцалтгүй тусламж, холбооны сан, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар цуглуулна гэж мэдэгдсэн.

Олон талт хөгжлийн банкууд, хөгжлийн санхүүгийн байгууллагууд, төрийн баялгийн сан болон бусад сангуудаас хэдэн зуун тэрбумын нэмэлт санхүүжилт орж ирж магадгүй юм.

Өнгөрсөн оны мөн үед Долоогийн бүлгийн орнуудын удирдагчид “Илүү сайн ертөнцийг бүтээцгээе” дэд бүтцийн санаачилгыг дэвшүүлж байсан бол “Дэлхийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын түншлэл” болгон нэрээ өөрчлөн уг төслийг албан ёсоор эхлүүлсэн байна.

ОХУ 1918 ОНООС ХОЙШ АНХ УДАА ГАДААД ӨР ТӨЛБӨРӨӨ ТӨЛЖ ЧАДАХГҮЙД ХҮРЭВ.

Барууны орнуудын ОХУ-д тавьсан хоригийн улмаас ОХУ хилийн чанад дахь бонд эзэмшигчдийн төлбөр төлөх зам суваг хаагдаж, улмаар 1918 оноос хойш анх удаагаа гадаад өр төлбөрөө төлж чадахгүйд хүрчээ. ОХУ Украин руу түрэмгийлснээс хойш хэдэн сарын туршид хориг арга хэмжээг тойрон гарахын тулд янз бүрийн арга хэрэглэж байсан ч 100 сая ам.долларын төлбөр төлөлтийн хугацаа нь дууссан байна.

2022 оны 3 дугаар сарын эхэн үеэс эхлэн ОХУ дахь Европын бондын үнэ зогсонги байдалд орж, Төв банкны гадаад валютын нөөц царцсан хэвээр байгаа бөгөөд тус улсын томоохон банкууд дэлхийн банкны системээс тусгаарлагдаад байна



ОРОСЫН ГАДААД ВАЛЮТЫН ӨРИЙГ РУБЛИЭР ТӨЛӨХ ТУХАЙ ЗАРЛИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЖЭЭ.

ОХУ–ын Ерөнхийлөгч Владимир Путин еврогоор гаргасан бондыг төлөх шинэ түр журмын тухай зарлигт гарын үсэг зуржээ. Баримт бичгийг хууль, эрх зүйн мэдээллийн албан ёсны цахим хуудсанд нийтэлсэн байна. Энэхүү баримт бичгийн дагуу Орос улс гадаад валютын өрөө рублиэр төлөх боломжтой болно.

Тогтоолд дурдсанаар, хэрэв гадаад валютаар хүлээсэн үүргийн дүнтэй тэнцэх хэмжээний рублиэр төлсөн бөгөөд ОХУ–ын дотоод валютын зах зээл дээрх гадаад валютын ханшаар тооцсон бол евро бондоор хүлээсэн үүргийг биелүүлсэн гэж үзнэ.

АНУ ОХУ–ЫН ЗАРИМ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАТВАРЫГ НЭМЭГДҮҮЛЖЭЭ.



ОХУ–тай худалдааны хэвийн харилцааг түр зогсоосонтой холбоотойгоор АНУ–ын засаг захиргаа тус улсын импортын зарим бараа бүтээгдэхүүний гаалийн татварын хэмжээг 35.0 хувь хүртэл нэмсэн тухай Цагаан ордон мэдээлсэн ба холбогдох баримт бичигт АНУ–ын Ерөнхийлөгч Жо Байден гарын үсэг зурсан байна.

Татварыг нь нэмсэн бараа бүтээгдэхүүний жагсаалт бүхий баримт бичгийн хавсралтыг одоогоор нийтлээгүй байна. АНУ ОХУ–аас 2.3 тэрбум ам.долларын үнэ бүхий 570 гаруй нэр төрлийн барааны гаалийн татварыг нэмэгдүүлнэ гэж мэдээлсэн.

КОМПАНИУДЫН ХУВЬЦАА ХУДАЛДСАНААС ОЛСОН ОРЛОГО ХАМГИЙН ДООД ТҮВШИНД ХҮРЛЭЭ.

Дэлхийн хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй компаниудын хувьцаагаа худалдсанаас олсон орлого 2022 оны эхний хагас жилд сүүлийн 19 жилийн хамгийн доод түвшинд хүрчээ. Тус хугацаанд компаниуд 196.4 тэрбум ам.доллар олсон нь өнгөрсөн оны мөн үеэс 70 хувиар буурсан үзүүлэлттэй байгааг “Nikkei” сонинд мэдээлсэн байна.



Тэр дундаа АНУ–ын корпорацуудын орлого ихээхэн буурсан ба мөн хугацаанд АНУ–ын корпорацуудын 6 дахин буурсан үзүүлэлттэй байв. Энэхүү үзүүлэлтээр АНУ–ын компаниуд статистик хөтөлж эхэлснээс хойш анх удаа БНХАУ–ын компаниудад байр сууриа алдсаныг онцлон тэмдэглэжээ.

Хөрөнгийн бирж дээр хувьцаа худалдсанаас олсон орлого ийнхүү буурсан нь тэргүүлэгч гүрнүүд инфляцын өсөлтийн эсрэг санхүүгийн бодлогоо чангаруулсан, мөн Украины үйл явдлын эргэн тойронд үүссэн хямралын нөлөөтэй холбоотой гэж шинжээчид үзэж байна.

ӨНГӨРСӨН САРД ӨМНӨД СОЛОНГОСЫН ИНФЛЯЦ СҮҮЛИЙН 24 ЖИЛИЙН ХАМГИЙН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЧЭЭ.

2022 оны эхний хагас жилд БНСУ–д инфляцын түвшин 1998 оны 11 дүгээр сараас хойших хамгийн дээд үзүүлэлт болсныг Үндэсний статистикийн газар мэдээллээ. Тус хугацаанд хэрэглээний үнийн өсөлт 1.4 хувиар буурсан бол, цахилгаан эрчим хүчний үнэ 0.1 хувиар, хий болон бусад төрлийн түлшний үнэ 2.9 хувиар тус тус өссөн байна.



Хүнс, шатахууны үнийг тооцохгүйгээр суурь инфляц өнгөрсөн оны мөн үеэс 3.9 хувиар өсжээ.

Хэрэв өсөлт энэ хэвээр үргэлжилбэл 2022 оны жилийн инфляц Өмнөд Солонгосын Сангийн яамны таамаглал болох 4.7 хувиас давна гэж шинжээчид үзэж байна.

АНУ БНХАУ-ЫН ТАВАН КОМПАНИЙГ ХАР ЖАГСААЛТАД ОРУУЛЖЭЭ.

Жо Байдены засаг захиргаа БНХАУ-д төвтэй таван компанийг ОХУ-ын батлан хамгаалах аж үйлдвэрийн салбарыг дэмжсэн гэх үндэслэлээр худалдааны хар жагсаалтад оруулсан байна.

Тус улсын Худалдааны яамын мэдээлснээр ОХУ Украин руу довтлохоос өмнө эдгээр таван аж ахуйн нэгжүүд нь ОХУ-ын “анхаарал татсан” байгууллагуудад бараа бүтээгдэхүүн нийлүүлж байсан бөгөөд дайн эхэлсний дараа ч үргэлжлүүлэн гэрээ хүлээн авсаар байжээ.

Мөн ОХУ, АНЭУ, Литва, Пакистан, Сингапур, Их Британи, Узбекистан, Вьетнам улсуудын 31 аж ахуйн нэгж уг жагсаалтад орсон талаар мэдээлжээ.

ИЗРАИЛ УЛС СҮҮЛИЙН 11 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХАМГИЙН ИХ ХЭМЖЭЭГЭЭР БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ӨСГӨВ.



Израилын Төв банк инфляцын өсөлтийг хязгаарлахын тулд бодлогын хүүгээ 0.5 хувиар өсгөж, 1.25 хувьд хүргэв. Энэ нь сүүлийн 11 жилийн хугацаанд бодлогын хүүгээ хамгийн их хэмжээгээр нэмэгдүүлж байгаа юм.

Украины нөхцөл байдал, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг хүчин зүйлсийн улмаас инфляцын дарамттай тулгарч байгаагаа мэдэгдсэн байна.

2022 онд Төв банк ийнхүү гурав дахь удаагаа хүүгээ нэмэгдүүлж байна. Төв банкны зүгээс бодлогын хүүг 0.1 хувьтай байлгадаг байсан бол 4 дүгээр сард 0.35 хувь, 5 дугаар сард 0.75 хувь хүртэл өсгөсөн. Нөхцөл байдал тогтворжихгүй бол бодлогын хүүг үргэлжлүүлэн чангаруулна гэдгээ илэрхийлсэн байна.

УКРАИНЫ ЭДИЙН ЗАСАГ 2022 ОНД 35 ХУВИАР АГШИНА.



Украины дотоодын нийт бүтээгдэхүүн 2022 онд мөргөлдөөний улмаас хамгийн багадаа 35 хувиар агшина гэж тус улсын Ерөнхий сайд Денис Шмыгаль мэдээлжээ

Украины статистикийн газрын мэдээлснээр, 2022 оны 1–3 дугаар сард ДНБ өнгөрсөн оны мөн үеэс 15.1 хувиар буурсан байна.


Украины Үндэсний банкны тооцоогоор сүүлийн хагас жилд эдийн засгийн агшилтын хурд арай бага байх боловч Украины бодит ДНБ жилийн хугацаанд 30 гаруй хувиар буурах төлөвтэй байна.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр

S&P 500 /^GSPC/


3,966.84 +5.21 (+0.13%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


27,693.77 -8.49 (-0.03%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,306.30 +29.93 (+0.41%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

11,782.67 -51.45 (-0.43%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia





Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia